

1. Хүмүүс ажиллаж сурч амьдарч буй аймаг, хот, сум, дүүрэг, баг, хорооны хүмүүс хоорондын харилцаа, нийгмийн бүлэг, байгууллагуудын хүрээг юу гэж нэрлэдэг вэ? А.Орон нутгийн байгууллага В.Орон нутгийн бүлэг С.Орон нутгийн орчин
- 2.АмерикийнсэтгэлсудлаачА.Маслоу1954онд хэвлүүлсэн “.....” хэмээх бүтээлдээ хүнд олон хэрэгцээ байдаг талаар дурьдсан байдаг. А. Сэдэл ба хувь хүн В. Сэдэл ба соёл С. Сэдэл ба органик нэгдэл Д. Сэдэл ба сэтгэгц
- 3.Зөрчилдөөнийг шийдвэрлэх алхмуудад буруу ойлголт байгаа бол олж дугуйлна уу? А. Шүүхээр шийдүүлэх В. Эвлэрүүлэн зуучлагч туслах С. Талууд ойлголцож шийдэлд хүрэх Д.Зөрчилдөөн үүсэхээс урьдчилан сэргийлсэн орчин Е.Буруу ойлголт байхгүй
4. нь тухайн нийгмийг бусад нийгмээс ялгах шинж, тухайн нийгмийн хөгжлийнх нь үндэс төдийгүй хүмүүс хойч үедээ өвлүүлдэг үнэт зүйл юм. А. Хувь хүний соёл В. Соёл С. Орон нутгийн соёл Д. Бүлэг байгууллагын соёл
5. нь эртний болон одоо үеийнхний эрхэмлэн дээдэлдэг үнэт зүйлс, тэдгээртэй харьцах зан үйл, арга ухаан юм. Орон нутгийн соёлд тухайн нутгийн зон олны хөгжлийн үндэс болж буй, эрт эдүгээд эрхэмлэсээр ирсэн, бас хойч үедээ өвлүүлэн үлдээх хүсэлтэй бүхий л үнэт зүйл хамаарна. А. Соёлын үнэт зүйл В. Соёл С. Орон нутгийн соёл Д. Хүн
6. 2012 оны байдлаар ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд манай улсаас гурван газрыг бүртгэжээ. Үүнд хамаарах газарт илүүц ойлголт дурьдсан бол олж дугуйлна уу? А. Увс нуурын ай савын газар байгалийн өвөөр В. Орхоны хөндийн соёлын дурсгалт газар С. Монгол Алтайн хадны сүг зургийн цогцолборыг түүх соёлын дурсгалт газар Д.Илүүц ойлголт байхгүй
7. Уртын дуу, монголын нууц товчоо, ардын уран зохиолын бүтээл, оньсого таавар нь соёлын ямар хэлбэр вэ? А. Материаллаг соёл В. Оюуны соёл С. Зонхилогч соёл
8. Өдөр тутмын аж төрөхүйд баримталдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил, уламжлал тэргүүтнийг бүхэлд нь хүмүүсийн харилцаа, нийгмийн дэг журмыг зохицуулж байдаг гэнэ. Тэдгээр нь зөв боловсон хувцаслах, көв ярих дүрэм журмаас эхлээд муу үйл үйлдэж болохгүй гэдэг сургаал хүртэл өргөн хүрээг хамардаг. Энэ утгаараа нь хувь хүн, бүлэг, байгууллага, нийгмийн соёлыг илтгэн харуулдаг гол үзүүлэлт мөн. А. Хэм хэмжээ В.Соёл С. Үнэт зүйл Д. Оюуны соёл
9. Соёлын өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлд илүүц ойлголт дурьдсан бол олж дугуйлна уу? А. Шинэ бүтээл ололт амжилт В. Соёлуудын харилцан нөлөөлөл, нэвчилт С. Байгаль орчин Д. Илүүц ойлголт байхгүй
10. Улс үндэстний соёлд материаллаг бүтээн босголтын зэрэгцээ хүн ардынх нь ёс суртахуун гарцаагүй чухал үүрэгтэй. Гэтэл бодит байдал дээр материаллаг зүйлсэд хэт их шунах нь зарим сөрөг үр дагаварт хүргэдэг. Үүнийг соёл судлаачид гэж нэрлэдэг. А. Соёлын өөрчлөлт В. Соёлын нэвчилт С. Соёлын гажилт Д. Соёлын хожимдол
11. Орон нутгийн соёлд илүүц ойлголт дурьдсан бол олж дугуйлна уу? а.Нутгийн иргэдийн аж төрөх ёс, хэл, аялгуу, аман болон бичгийн соёл б.Ёс, зан заншил, шашин шүтлэг с.Дуу хөгжим, бүжиг, тэдгээрийг гүйцэтгэх арга барил д.Түүх, соёлын дурсгалт газар е.Ямар нэгэн үйл ажиллагааг хийх арга барил, туршлага, дадал чадвар ф.Соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах, бүтээх, эзэмших, ашиглах, түгээн дэлгэрүүлэх, нийтийн хүртээл болохтой холбоотой үйл ажиллагаа j. Илүүц буруу ойлголт байхгүй.
12. Дараах ойлголт зөв юу? Соёл нь нийт хүн төрөлхтний зүгээс хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээхийг хүсэж байдаг үнэт зүйлс, бас өдөр тутмын аж төрөхүйд баримталдаг дэг журам, ёс заншил, уламжлалыг зохицуулж байдаг хэм хэмжээ мөн. А. Зөв В. Мэдэхгүй С. Буруу ойлголт

1	Байгалийн өв	А	Увс нуурын ай сав
2	Соёлын дурсгал	В	Орхоны хөндий
3	Түүх соёлын дурсгал	С	Монгол Алтайн хадны сүг зураг

А. 1А 2В 3С В. 1С 2А 3В С. 1В 2А 3С Д. 1С 2В 3А

14. Улс үндэстний соёлд материаллаг бүтээн босголтын зэрэгцээ хүн ардынх нь ёс суртахуун гарцаагүй чухал үүрэгтэй. Гэтэл бодит байдал дээр материаллаг зүйлсэд хэт их шунах нь зарим сөрөг үр дагаварт хүргэдэг. Үүнийг соёл судлаачид гэж нэрлэдэг. А. Соёлын өөрчлөлт В. Соёлын нэвчилт С. Соёлын гажилт Д. Соёлын хожимдол

15. Орон нутгийн соёлд илүүц ойлголт дурьдсан бол олж дугуйлна уу?

а. Нутгийн иргэдийн аж төрөх ёс, хэл, аялгуу, аман болон бичгийн соёл б. Ёс, зан заншил, шашин шүтлэг с. Дуу хөгжим, бүжиг, тэдгээрийг гүйцэтгэх арга барил д. Түүх, соёлын дурсгалт газар е. Ямар нэгэн үйл ажиллагааг хийх арга барил, туршлага, дадал чадвар ф. Соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах, бүтээх, эзэмших, ашиглах, түгээн дэлгэрүүлэх, нийтийн хүртээл болохтой холбоотой үйл ажиллагаа г. Илүүц буруу ойлголт байхгүй.

2-р түвшин

16. Нутгийн өвгөн ярихдаа уул уурхай, ашигт малтмалаас шалтгаалаад туул гол маш их бохирдсоныг баримтад тулгуурлан тайлбарласан. Мөн туул голоо явал сэргээж сайхан болгох тухай яриандаа ийнхүү дурджээ. Уул уурхайг эрхлэн явуулж байгаа хүмүүс нь нөхөн сэргээлтийг сайн хийгээд мод бут тариад байвал Туул голын ус цэвэрших, усны нөөц нэмэгдэх тал байгаа харагддаг юм. Энэ нь таамаглал, санаа бодол, баримтын аль ойлголтыг илэрхийлж байна вэ? Санаа бодол, таамаглал, баримт тус бүр дээр жишээ бичээрэй.



1.....
2.....
3.....

17.

17. Зөрчлөөс сэргийлэх ямар, ямар аргууд байдаг вэ?

18. "Үйлдвэр хөгжсөн ихэнх улс орнуудад 90 гаруй хувь нь хотод амьдарч, 2-3% нь хөдөө аж ахуйд ажиллаж амьдарч байна." гэсэн мэдээлэлд тулгуурлан, соёлын өөрчлөлтийн эерэг болон сөрөг үр дагавруудыг нэрлэж бичээрэй.....

1-р түвшин тест бөглөх хүснэгт:

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
A															
B															
C															
D															
F															

1.Тухайн орон нутгийн орчинд байгаа сургууль, цэцэрлэг, худалдааны төв, номын сан, цагдаагийн хэлтэс эдгээрийг юу гэж нэрлэдэг вэ? А.Орон нутгийн байгууллага В.Орон нутгийн бүлэг С.Орон нутгийн орчин

2. Хувь хүмүүс өрх гэрүүд хоршин амьдрах шалтгаан нь хоёр үндсэн хэв шинжтэй байдаг гэж тайлбарласан эрдэмтэн хэн бэ? А. М.Вебер В.К.Маркс С.Э.Дюркгейм D.А.Маслоу

3. Зөрчилдөөний талаар дараах ойлголтод буруу ойлголт байгаа бол олж дугуйлна уу? А.Зөрчилдөөн нь талуудын сонирхол, эрх ашгийг хөндсөн санал зөрөлдөөн юм. В. Зөрчилдөөн нь нийгмийн харилцааны салшгүй нэг хэсэг юм. С. Хүчирхийлэл бол зөрчилдөөн биш харин зөрчилдөөний сөрөг үр дагавар юм. Зөрчилдөөнд оролцогч талууд, тэдний зорилго, эрх ашиг, санал зөрөлдөөний улмаас талуудад учирч болох эрсдэл юу вэ гэдгийг ойлгох нь чухал. D.Зөрчилдөөн нь хүмүүсийн харилцааны алдаа, буруу ойлголцол болон нийгэм, соёлын суурь шалтгаанаас үүдэн гарч болно. E.Буруу ойлголт байхгүй F.Эвлэрүүлэн зуучлагч нь маргалдагч талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх, хэлцэл хийхэд туслах үүрэг хүлээдэг.

4. Соёлыг бүтээгч болон тээгчээс нь шалтгаалж дараах байдлаар ангилна.

А. Хувь хүний соёл б. Бүлэг байгууллагын соёл с. Орон нутгийн соёл d.Улс үндэстний соёл

5. Аливаа улс орны үнэт баялаг нь мөн А. Соёлын үнэт зүйл В. Соёл С. Орон нутгийн соёл D. Хүн

6. Хүний болон хүн, байгаль хоёрын харилцан үйлчлэлийн дүнд бий болсон гайхамшигт бүтээл, бүх талын ач холбогдол бүхий түүхийн дурсгалт газрыг багтаасан бүс нутгийг гэж нэрлэдэг. А. соёрхол газар В. дурсгалт газар С. Дархан цаазат газар D. төрийн газар

7. Дараах ойлголтод буруу ойлголт байгаа бол олж дугуйлна уу? А. Соёл нь биет (материаллаг) ба биет бус (оюуны) гэсэн хоёр хэлбэртэй. В.Материаллаг соёлд байшин барилга, хөшөө дурсгал, археологийн олдвор, машин техник гэх мэт тодорхой биет зүйлс хамаардаг. С. Оюуны соёлд шашин, домог үлгэр, зан заншил, баяр наадам, шинжлэх ухаан, мэдлэг, боловсрол, урлаг гэх мэт биетээр оршин байх боломжгүй, зөвхөн хүний оюун санаагаар дамжин өвлөгддөг зүйлсийг багтаадаг. D.Буруу ойлголт байхгүй

8. Төрийн тамга, түүх соёлын дурсгал, хөшөө дурсгал, эртний эдлэл гэх мэт нь соёлын ямар хэлбэр вэ? А. Материаллаг соёл В. Оюуны соёл С. Зонхилогч соёл

9. Дараах ойлголтод буруу өгөгдөл байгаа бол олж дугуйлна уу? А. Өдөр тутмын аж төрөхүйд баримталдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил, уламжлал тэргүүтнийг бүхэлд нь хүмүүсийн харилцаа, нийгмийн дэг журмыг зохицуулж байдаг хэм хэмжээ гэнэ.В. Хэм хэмжээг албан болон албан бус гэж хоёр ангилна. С. Албан хэм хэмжээнд хууль, дүрэм, журам хамаарна. D. Албан бус хэм хэмжээнд зан заншил, ёс суртахуун хамаарна. E. Буруу өгөгдөл байхгүй байна

10. Уртын дуу, монголын нууц товчоо, ардын уран зохиолын бүтээл, оньсого таавар нь соёлын ямар хэлбэр вэ? А. Материаллаг соёл В. Оюуны соёл С. Зонхилогч соёл D.Сөрөг соёл

11. 1876 онд телефон, 1903 онд агаарын тээвэр, XX зуунд компьютерийг бүтээсэн нь хүн төрөлхтний амьдрал соёлын хэв маяг, харилцаанд онцгой өөрчлөлт оруулсан билээ. А. Шинэ бүтээл ололт амжилт В. Соёлуудын харилцан нөлөөлөл, нэвчилт С. Байгаль орчин D. Соёлын өөрчлөлт

12. Соёлын үйл ажиллага эрхэлдэг байгууллагад илүүц ойлголт дурьдсан бол олж дугуйлна уу? а.Сургууль, цэцэрлэг, амралт сувиллын газар, б.Орон нутгийн телевиз, радио, сонин, хэвлэлийн газар, с. Амьтаны хүрээлэн d. Спорт клубийн үйл ажиллагаа e.Илүүц ойлголт байхгүй.

13. Соёлын зүйл нэг бүлгээс нөгөөд, нэг нийгмээс нөгөөд дэлгэрэх үйл явцыг гэдэг. Жишээ нь, манай ард түмэн эрт дээр үеэс нүүдлийн соёл уламжлалаа хадгалсаар ирсэн билээ. XVII-XX зууны эхэн үе хүртэл Монголд буддын шашин хүчтэй дэлгэрч, хүрээ хийдийн хэдэн зуун төвүүд байгуулагдсанаар хүн амын тодорхой хэсэг суурин маягаар аж төрөх эхлэл тавигдсан байдаг. А. Соёлын өөрчлөлт В. Соёлын нэвчилт С. Соёлын гажилт D. Соёлын хожимдол

14. Улс үндэстний соёлд материаллаг бүтээн босголтын зэрэгцээ хүн ардынх нь ёс суртахуун гарцаагүй чухал үүрэгтэй. Гэтэл бодит байдал дээр материаллаг зүйлсэд хэт их шунах нь зарим сөрөг үр дагаварт хүргэдэг. Үүнийг соёл судлаачид гэж нэрлэдэг. А. Соёлын өөрчлөлт В. Соёлын нэвчилт С. Соёлын гажилт D. Соёлын хожимдол

15. Дараах ойлголт зөв юу? А. Соёл бол тогтворгүй зүйл биш. Тэр үүсч хөгжиж нэг ард түмэн, улс орноос нөгөөд түгэн дэлгэрч, өнгөрсөн үеийнхнээс хойч үеийнхэнд уламжлагдан дамжиж, нэг хэсэг нь бас өөрчлөгдөж эсвэл мартагдаж байдаг. В. Соёлын өөрчлөлтөд шинэ бүтээл, ололт амжилт, соёлын харилцаа, байгалийн хүчин зүйлс нөлөөлдөг. С. Аливаа шинэ бүтээл бол оршин байгаа соёлыг шинэ хэлбэртэй болгодог D. Соёлын зүйл нэг бүлгээс нөгөөд нэг, нэг нийгмээс нөгөөд дэлгэрэх үйл явцыг соёлын нэвчилт гэдэг. E. Улс үндэстний соёлд материаллаг бүтээн босголтын зэрэгцээ хүн ардынх нь ёс суртахуун гарцаагүй чухал үүрэгтэй. Гэтэл бодит байдал дээр материаллаг зүйлсэд хэт их шунах нь зарим сөрөг үр дагаварт хүргэдэг. Үүнийг соёл судлаачид соёлын хожимдол гэж нэрлэдэг. А. Зөв В. Мэдэхгүй С. Буруу ойлголт

2-р түвшин 16. Зурагт голын бохирдол, хог хаягдлыг харуулжээ. Энэ нь баримт, таамаглал, санаа бодлын аль нь вэ? Баримт, таамаглал, санаа бодол тус бүр дээр жишээ бичээрэй.



1.....

2.....

3.....

17. Тохиолдол. Хөрш зэргэлдээ 2 сумын малчдын дунд маргаан үүсжээ. Хэдийгээр өөр өөр сумын харьяат боловч малаа хариулж, зусдаг бэлчээр нь нэг ажээ. Энэ жил өмнө талын сумын зуншлага тааруу, ногооны гарц сайнгүй байсан тул хойд сумын бэлчээрт малчид малаа бэлчээв. Хойд сумын зарим малчин үүнийг эсэргүүцэж маргаан өдөөжээ. 2 малчны маргааныг эергээр шийдэх аргыг тэмдэглээрэй - Энэ зөрчилдөөний шалтгаан юу байна вэ?.....

- Та бүхэн эвлэрүүлэн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх хэрэгтэй болжээ. Талуудын маргааныг үр дүнтэй, шударга шийдвэрлэх арга замыг санал болгоорой..... 18. Соёлын өөрчлөлт болон хожимдол ойлголтын зэрэг, сөрөг тал тус бүрд 1 жишээ бичээрэй.

Соёлын өөрчлөлт				Соёлын хожимдол			
Эерэг тал		Сөрөг тал		Эерэг тал		Сөрөг тал	
.....							

1-р түвшин (төст бөглөх хүснэгт)

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	
A																
B																
C																
D																
F																